

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС
БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг Чех Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр Бүгд Найрамдах Чех Улсад манай улсын хэчнээн иргэн байнга оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа, өнгөрсөн хугацаанд гэмт хэрэгт холбогдсон талаарх судалгаа, мэдээлэл байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс үг хэлээгүй болно.


Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

~~ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ~~
~~МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН~~
~~ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ~~

1 дүгээр зүйл. Монгол Улс, ~~боловч~~ Бүгд Найрамдах Чех Улс хооронд 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай” ~~Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг~~ Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг